



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/26

Чингис хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 12 дугаар хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 12 дугаар хуралдааны 08 дугаар тогтоолын 02, 03 дугаар хавсралтаар батлагдсан "Аймгийн төсвийн хөрөнгөөр 2020 оны төсвийн жилд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт", "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалт"-аас сумдад эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журмын дагуу шуурхай зохион байгуулж, гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Дэмбэрэлсайхан/-д, барилга угсралт, их засварын ажлын захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Д.Баярхүү/-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА



231010112

Аймгийн Засаг даргын 2020 оны
...01... дугаар сарын 21...өдрийн А/26...
дугаар захирамжийн хавсралт

№	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	2020 онд санхүүжих
1	Бэрх тосгоны Захирагчийн ажлын албанд автомашин	50,000.0	50,000.0
2	Аврах бүлгийн байр засварлахад дэмжлэг үзүүлэх /Жаргалтхаан/	10,000.0	10,000.0
3	Аврах бүлгийн байр засварлахад дэмжлэг үзүүлэх /Баян-Адарга/	10,000.0	10,000.0
4	Баян-Овоо сумын замын засвар	9,500.0	9,500.0
5	Тэнхлэг, Баянбулаг голын модон гүүр шинээр байгуулах /Дадал/	50,000.0	50,000.0
6	Норовлин сумын хөндлөнгийн гүүрийн засвар	10,000.0	10,000.0
7	Зуухын Баянголын модон гүүр шинээр байгуулах /Батширээт/	30,000.0	30,000.0
8	Шөнийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх /Хэрлэн/	300,000.0	300,000.0
9	Хогийн цэгийн хашаажуулалт /Баян-Овоо сум/	80,000.0	50,000.0
10	Ундны усны худаг байгуулах /Галшар сумын Буянтбулаг/	17,000.0	17,000.0
11	Усан оргилууруудын засвар /Хэрлэн/	15,000.0	15,000.0